



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/23/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261885 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг
Утас: 261740 Цахим хаяг: erdenetsetegi@audit.gov.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.4.2 Авлага	13
3.4.3 Урьдчилгаа	14
3.4.4 Бараа материал	14
3.4.5 Үндсэн хөрөнгө	15
3.4.6 Өр төлбөр	15
3.4.7 Засгийн газрын хувь оролцоо.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХЗТЛ	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
УЦУОСМХ	Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26 04 37, Факс: 51 26 42 30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, УРЬДЧИЛАН
МЭДЭЭЛЭХ ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ОЮУНЖАРГАЛ ТАНАА

2024.03.25 № 07/489
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 26 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 17 байгууллага "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, 9 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний 22 төв, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв, Цаг уур, орчны шинжилгээний газар, нийт 26 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэж, тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагч нь 9 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 84.4 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд энэ мэдээлэл хамааралгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,006,702.7	10,317,601.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	193,487.5	347,457.3
33	АВЛАГА	718,736.1	1,248,135.8
34	УРЬДЧИЛГАА	0.0	2,736.0
35	БАРАА МАТЕРИАЛ	13,074,479.0	8,719,272.5
36	НӨӨЦИЙН БАРАА	20,000.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,054,104.3	38,257,803.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,054,104.3	38,257,803.2
39200	Биет хөрөнгө	21,015,482.4	28,888,369.9
39300	Биет бус хөрөнгө	9,038,621.9	9,369,433.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,060,807.0	48,575,404.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	171,892.9	215,846.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	171,892.9	215,846.0
41300	Өглөг	171,892.9	215,846.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	43,888,914.1	48,359,558.7
51	Засгийн газрын хувь оролцоо	43,888,914.1	48,359,558.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	25,693,349.1	26,012,280.1
51200	Хуримтлагдсан үр дүн	13,825,024.7	18,010,916.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,370,540.3	4,336,362.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,060,807.0	48,575,404.7

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	44,206,620.9	58,939,001.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,645,081.2	6,708,528.2
120	Нийтлэг татварын бус орлого	7,645,081.2	6,708,528.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,561,539.7	52,230,473.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	41,737,499.4	54,668,170.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,415,414.9	54,668,170.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,731,295.1	51,978,068.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,325,542.1	36,912,149.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,065,829.2	4,526,031.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,029,574.7	1,348,632.7
2104	Хангамж, бараа материалын зардал	1,070,249.7	1,329,211.4
2105	Нормативд зардал	27,269.8	103,381.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,011,774.5	754,865.1
2107	Томилолт, зочны зардал	147,047.0	196,385.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,104,853.0	1,104,607.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,949,155.2	5,702,804.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,684,119.8	2,690,102.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	322,084.5	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,469,121.5	4,270,830.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,317.1	144,812.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,417,804.4	4,126,017.6

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	41,422,871.2	0.0	41,422,871.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	244,771.0	0.0	244,771.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,667,642.2	0.0	41,667,642.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-196,532.5	0.0	-196,532.5
9	Тайлант үеийн үр дүн	2,417,804.4	0.0	2,417,804.4
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	43,888,914.1	0.0	43,888,914.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	59,874.0	0.0	59,874.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	43,948,788.1	0.0	43,948,788.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-34,178.0	0.0	-34,178.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	318,931.0	0.0	318,931.0
19	Тайлант үеийн үр дүн	4,126,017.6	0.0	4,126,017.6
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,359,558.7	0.0	48,359,558.7

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	36,760,799.8	52,610,838.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,235.4	312,763.1
120	Нийтлэг татварын бус орлого	147,235.4	312,763.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,613,564.4	52,298,075.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,326,290.2	51,333,510.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,326,290.2	51,333,510.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,565,788.2	48,219,584.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,345,498.8	36,875,496.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,072,637.7	4,609,399.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,025,325.9	1,356,503.1
2104	Хангамж, бараа материалын зардал	485,980.9	677,430.5
2105	Нормативд зардал	63,666.4	101,849.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,107,340.9	3,084,831.4
2107	Томилолт, зочны зардал	147,470.0	203,755.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,238,130.3	1,139,820.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,737.3	170,497.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,760,502.0	3,113,926.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,434,509.6	1,277,327.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,837,161.7	1,123,357.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,837,161.7	1,123,357.4
2200	Дотоод эх үүсвэрээр	2,837,161.7	1,123,357.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,837,161.7	-1,123,357.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,402,652.1	153,969.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,596,139.6	193,487.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,487.5	347,457.3

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,665,030.2	48,940,083.7	-724,946.5	98.5
УРСГАЛ ЗАРДАЛ	49,665,030.2	48,940,083.7	-724,946.5	98.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,838,424.6	47,345,266.7	-493,157.9	99
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,943,450.2	36,570,147.8	-373,302.4	99
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,626,378.0	4,569,252.7	-57,125.3	98.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,377,709.4	1,347,224.4	-30,485.0	97.8
Хангамж, бараа материалын зардал	437,691.5	432,474.0	-5,217.5	98.8
Нормативд зардал	69,052.6	69,039.7	-12.9	100
Эд хогшил, урсгал засварын зардал	3,415,583.8	3,403,369.3	-12,214.5	99.6
Томилолт, зочны зардал	97,552.9	96,501.0	-1,051.9	98.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	752,517.5	738,895.8	-13,621.7	98.2
Бараа үйлчилгээний бусад зардал	118,488.7	118,362.1	-126.6	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,826,605.6	1,594,817.0	-231,788.6	87.3
Бусад урсгал шилжүүлэг	1,826,605.6	1,594,817.0	-231,788.6	87.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,665,030.2	48,940,083.7	-724,946.5	98.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	49,595,100.2	48,795,431.4	-799,628.8	98.4
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	69,930.0	144,652.3	74,682.3	206.8
БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	0	100
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,893	1,814	-79	95.8
Удирдах ажилтан	63	53	-10	84.1
Гүйцэтгэх ажилтан	1,744	1,680	-64	96.3
Үйлчлэх ажилтан	86	81	-5	94.2



Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,561,325.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,561,325.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,705,132.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		305,349.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		40,146.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,278.7
2104	Хангамж, бараа материалын зардал		246,370.3
2105	Нормативд зардал		32,809.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		421,106.6
2107	Томилолт, зочны зардал		107,254.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		500,272.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		42,544.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		856,193.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		419,865.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		436,327.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,561,325.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,561,325.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цаг уур, орчны шинжилгээний газар нь эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Цаг уур, орчны шинжилгээний газар нь:

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ус цаг уур орчны шинжилгээний салбарт өнөөгийн байдлаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Агаарын тухай, Байгалийн ургамлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Усны тухай зэрэг гол хуулиудаас гадна салбарын хамаарал бүхий 12 хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор баталсан 9 үндэсний хөтөлбөр, 11 үзэл баримтлал, үндсэн чиглэл, төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- ТБОНӨХБАҮХА тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн найруулга;
- Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тоот тогтоол;
- Бусад холбогдох хууль, дүрэм журам.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд байгууллагын бүтцэд дотоод аудиторын 1 орон тоо батлагдан, ажиллаж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

БОАЖЯ-ны ХШҮДАГ-аас тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд 2023 онд УЦУОСМХ-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2023 онд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон өөрчлөлтүүдийг оруулж шинэчилсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,514.6 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, Бууралт/-
Мөнгөн хөрөнгө	193,487.5	347,457.3	153,969.8
Авлага	718,736.1	1,248,135.8	529,399.7
Урьдчилгаа	-	2,736.0	2,736.0
Бараа материал	13,074,479.1	8,719,272.5	-4,355,206.6
Нөөцийн бараа	20,000.0	0.0	-20,000.0
Үндсэн хөрөнгө	30,054,104.3	38,257,803.1	8,203,698.8
НИЙТ ХӨРӨНГӨ	44,060,807.0	48,575,404.7	4,514,597.7
Өглөг	171,892.9	215,846.0	43,953.1
Засгийн газрын хувь оролцоо	43,888,914.1	48,359,558.7	4,470,644.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ	44,060,807.0	48,575,404.7	4,514,597.7
ӨМЧИЙН ДҮН			

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 154.0 сая төгрөг, авлага дансны үлдэгдэл 529.4 сая төгрөг, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,203.7 сая төгрөг, Засгийн газрын хувь оролцоо 4,470.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бараа материал дансны үлдэгдэл 4,355.2 сая төгрөгөөр буурсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 347.5 сая төгрөг болж, 154.0 сая төгрөгөөр өссөн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	168,964.5	168,964.5	0.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	24,523.0	178,492.8	153,969.8
Дүн	193,487.5	347,457.3	153,969.8

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд Цаг уур, орчны шинжилгээний газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хиймэл дагуулын цамхгийн байр барих ажлын гүйцэтгэлийн барьцааны 169.0 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, харьяа байгууллагуудын ахмадын сангийн 178.5 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын цаг уурын өртөөний барилгын урсгал засварын ажлыг гүйцэтгээгүй, санхүүжилтийн үлдэгдэл 9.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн, төсвийн хэмнэлтийн 8.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй, зарцуулсан байна. /Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-д 2 албан шаардлага/
- Хоолны хөнгөлөлт 1.1 сая төгрөгийг давхардуулан олгосон. /Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-д төлбөрийн акт тогтоосон/
- Ахмадын сангийн дансанд тайлант оны эцэст төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн. /Архангай аймгийн УЦУОШТ-д төлбөрийн акт тогтоосон/
- Цаг агаарын мэдээний тодорхойлолтыг үнэлэн, тайлангийн хугацаанд 2.4 сая төгрөгийн орлого олсон боловч байгууллагын дансанд төвлөрүүлээгүй, байгууллагын дэргэдэх ТББ-ын дансанд төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулсан. /Булган аймгийн УЦУОШТ-д төлбөрийн акт тогтоосон/
- Албан хэрэгцээнд нэр бүхий 1 ААН-ээс 18.9 сая төгрөгийн зөөврийн компьютер, процессор, принтерийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан байна. /Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид албан шаардлага /
- Албан хэрэгцээнд нэр бүхий 5 ААН-ээс 26.8 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан байна. /УЦУОСМХ-албан шаардлага/
- Байгаль орчны менежментийн олон улсын төв /ICEM/-тэй хамтарсан "ICEM TA MON 9440 Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх" ажилд "ТХ" ХХК-тай 32.0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан. /УЦУОСМХ-зөвлөмж/
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээний хэмнэлтээс оны эцэст 107.1 сая төгрөгийн компьютер, техник хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бусад этгээдээс шууд худалдан авсан. /УЦУОШГ-албан шаардлага/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,248.2 сая төгрөг болж, 529.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	17,058.2	19,113.8	2,050.6
Татаас санхүүжилтийн авлага	67,617.1	378,842.8	311,225.7
Байгууллагаас авах авлага	634,060.8	850,179.2	216,123.4
Дүн	718,736.1	1,248,135.8	529,399.7

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл нэмэгдэхэд ЦУОШГ-ын БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум пуужин худалдан авах 794.5 сая төгрөг, УЦУОСМХ-ийн татаас санхүүжилтийн 378.9 сая төгрөгийн авлага үүссэн нь голлон нөлөөсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2.7 сая төгрөг болж, өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал		0.0	2,736.0
Дүн		0.0	2,736.0

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

ЦУОШГ-ын БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум пуужинг авах ажилчдын томилолтын урьдчилгаанд 2.7 сая төгрөг олгож бүртгэсэн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 8,716.2 сая төгрөг болж, өмнөх оноос 4,378.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	10,973,085.4	6,413,714.8	-4,559,370.6
Тусгай зориулалтын материал	6,260,281.8	6,355,306.6	95,024.8
Эм боох материал	37,947.2	36,862.1	-1,085.1
Бэлэн бүтээгдэхүүн	460.0	340.0	-120.0
Дуусаагүй үйлдвэрлэл	4,674,396.4	21,206.1	-4,653,190.3
Хангамжийн материал	2,040,138.6	2,247,026.9	206,888.3
Бичиг хэргийн материал	104,353.8	104,835.9	482.1
Аж ахуйн материал	484,046.0	470,433.6	-13,612.4
Сэлбэг хэрэгсэл	798,208.0	876,899.0	78,691.0
Түлш, шатах тослох материал	33,978.1	42,348.1	8,370.0
Барилгын засварын материал	17,246.4	63,210.5	45,964.1
Бусад хангамжийн материал	602,306.3	689,299.8	86,993.5
Нөөцийн бараа	20,000.0	0.0	-20,000.0
Мал амьтан	61,255.0	55,470.8	-5,784.2
Дүн	13,094,479.0	8,716,212.5	-4,378,266.5

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,037.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан, бусдаас үнэ төлбөргүй 2,920.3 сая төгрөгийн төгрөгийн бараа материалыг авсан, 9,073.5 сая төгрөгийн бараа материалыг тайлант онд зарцуулж, харьяа байгууллагуудад 2,259.5 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлсэн лабораторийн бодис урвалжийг бүртгэлд тусгаагүй. /Булган аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлсэн лабораторийн бодис урвалжийг бүртгэлд тусгаагүй, жилийн эцсийн үлдэгдэлд тоологдоогүй. /Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Нэмэлт санхүүжилтийн данснаас "ТӨ" ХХК руу мэдээллийн самбарын үнэнд 0.7 сая төгрөг шилжүүлж, бараа материалыг биетээр ирээгүй байхад бичиг хэргийн материалын дансанд орлогоор бүртгэж, зарлагдсан. /Орхон аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа авто машинд зарцуулсан 4.5 сая төгрөгийн шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй. /Дундговь аймгийн УЦУОШТ-д албан шаардлага/

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 38,257.8 сая төгрөг болж, өмнөх оноос 8,203.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	21,015,482.4	28,888,370.0	7,872,887.6
Барилга, байгууламж, орон сууц	9,680,161.0	16,531,547.4	6,851,386.4
Авто-тээврийн хэрэгсэл	1,682,762.4	1,980,209.6	297,447.2
Машин, тоног төхөөрөмж (компьютер)	9,171,635.4	9,692,778.2	521,142.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	301,323.6	486,564.4	185,240.8
Бусад үндсэн хөрөнгө	176,346.4	193,866.8	17,520.4
Ном	3,253.6	3,403.6	150.0
Биет бус хөрөнгө	9,038,621.9	9,369,433.2	330,811.3
Программ хангамж	236,626.0	246,805.0	10,179.0
Бусад биет бус хөрөнгө	8,801,995.9	9,122,628.2	320,632.3
Дүн	30,054,104.3	38,257,803.2	8,203,698.9

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайланд онд хөрөнгө оруулалтын санхүүжилт болон урсгал санхүүжилтээр 840.4 сая төгрөг, бусад байгууллагаас шилжүүлэн авсан 844.0 сая төгрөг, хандив тусламжаар 140.3 сая төгрөг, дуусаагүй үйлдвэр данс болон дахин үнэлгээгээр 11,074.4 сая төгрөг, нийт 12,899.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын 2023 оны 29 дүгээр тогтоол, тус газрын даргын 2023 оны А/30 дугаар тушаалаар үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан 190.9 сая төгрөг, балансаас балансад хөрөнгө шилжүүлсэн 66.5 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 507 дугаар тогтоол, тус газрын даргын 2023 оны А/231 дүгээр тушаалаар дахин үнэлгээний хорогдуулга 772.0 сая, газрыг залруулж дахин шинэчилж бүртгэж тайлагнасан 119.6 сая төгрөг, нийт 1,146.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,203.7 сая төгрөгөөр нэмэгдэхэд ЦУОШГ-ын дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байсан Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах антену цамхгийн байрыг ТӨБЗГ-ын 2023 оны 665, 722 дугаар тогтоолууд, тус газрын даргын А/301 дүгээр тушаалаар 5,936.1 сая төгрөгөөр, тэг өртөгтэй үндсэн хөрөнгийг дахин үнэлж орлогод авсан 4,695.0 сая төгрөг, Архангай аймгийн УЦУОШТ 68.7 сая төгрөг, Говь-Алтай аймгийн УЦУОШТ 124.3 сая төгрөг, Хэнтий аймгийн УЦУОШТ 236.7 сая төгрөг, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн 13.5 сая төгрөг, нийт 443.2 сая төгрөгийн газруудыг үнэлж орлогод авсан нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Хөрөнгийн тооллогын акт, үр дүнг баталгаажуулсан жагсаалтыг нягтлан бодогчид хүлээлгэн өгөөгүй, эд хариуцагчийн тайланг холбогдох заавар маягтын дагуу гаргаагүй. /Дундговь аймгийн УЦУОШТ-д зөвлөмж /
- Үндсэн хөрөнгийн анхан шатны маягыг бүрэн хөтлөөгүй. /Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19 нэр төрлийн 42,999.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. /Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид-зөвлөмж/

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 215.8 сая төгрөг болж, өмнөх оноос 44.0 сая төгрөгөөр өссөн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн/+, Буурсан/-
Ажилчидтай холбогдсон өглөг	293.0	10,575.7	10,282.7
Байгууллагад төлөх өглөг	168,964.5	205,270.3	36,305.8
Хувь хүмүүст төлөх өглөг	2,635.3	0.0	-2,635.3
Нийт дүн	171,892.8	215,846.0	43,953.2

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөг дансны үлдэгдэлд ЦУОШГ-ын чанарын баталгааны өглөг 168.9 сая төгрөг, УЦУОСМХ-ийн 25.3 сая төгрөг, Дундговь аймгийн УЦУОШТ-ийн 10.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн УЦУОШТ-ийн 9.3 сая төгрөг, Дорнод аймгийн УЦУОШТ-ийн 1.1 сая төгрөг, Дорноговь аймгийн УЦУОШТ-ийн 0.6 сая төгрөг, нийт 215.8 сая төгрөг байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 48,359.6 сая төгрөг болж, өмнөх оноос 4,470.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, Бууралт/-
Засгийн газрын оруулсан капитал	25,693,349.1	26,012,280.1	318,931.00
Хуримтлагдсан үр дүн	13,825,024.7	18,010,916.2	4,185,891.50
Өмнөх үеийн үр дүн	11,407,220.2	13,884,898.6	2,477,678.40
Тайлант үеийн үр дүн	2,417,804.4	4,126,017.6	1,708,213.20
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,370,540.3	4,336,362.4	-34,177.90
Нийт дүн	43,888,914.1	48,359,558.7	4,470,644.6

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өсөхөд тайлант үеийн үр дүн 1,708.2 сая төгрөг, харьяа байгууллагуудад аудитын зөвлөмжөөр өмнөх үеийн үр дүн дансанд 59.9 сая төгрөгийг залруулсан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 42,248.4 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 69.9 сая төгрөг, нийт зарлагыг 42,318.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн анхны саналыг 7,218.8 сая төгрөгөөр бууруулан 35,099.6 сая төгрөгөөр баталж, төсвийн 2 удаагийн тодотголоор нийт 14,565.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 49,665.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 9,107.9 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,146.6 сая төгрөг, нийт 10,254.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалтын зардлыг 561.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 590.1 сая төгрөг, нормативд зардлыг 68.2 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 1,125.4 сая төгрөг, томилолтын зардлыг 120.9 сая төгрөг, бусдаар

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
 гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 136.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 138.9 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 166.8 сая төгрөг, нийт 2,907.8 сая төгрөгөөр бууруулж нийт санхүүжилтийг 49,665.0 сая төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 49,449.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоор 144.6 сая төгрөг нийт 49,593.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 653.7 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71408	Цаг уур, орчны шинжилгээ	49,665,030.2	48,940,083.7	-724,946.5	98.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	45,891,577.0	45,416,739.5	-474,837.5	99.0
80220	Холбооны суваг ашигласны хөлс	318,830.7	311,272.2	-7,558.5	97.6
81710	Ус цаг уурын судалгаа, шинжилгээ	1,624,209.0	1,613,447.1	-10,761.9	99.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамш	1,826,605.6	1,594,817.0	-231,788.6	87.3
80219	Харуул, хамгаалалтын зардал	3,807.9	3,807.9	0.0	100.0

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчид бусад этгээдээс 1,450.0 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-аас 615.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 73.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 421.7 сая төгрөг, нийт 2,561.3 сая төгрөгийн орлогыг эх үүсвэр бүрдүүлж 436.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин, НДШ-д 345.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 9.3 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 246.4 сая төгрөг, эм боох материалын зардалд 32.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 421.1 сая төгрөг, албан томилолтын зардалд 107.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 500.3 сая төгрөг, бараа үйлчилгээний зардалд 42.5 сая төгрөг, тэтгэмж урамшууллын зардалд 419.9 сая төгрөг, нийт 2,125.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор И.Эрдэнэцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ч.Болд, газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/155 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 37,771.0 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 377.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дахин үнэлж материаллаг байдлын байдлыг 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 54,668.2 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 546.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлыг талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,618.7 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 1,222.5 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 396.2 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой 417.0 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 417.0 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн аудитын асуудал нь Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн УЦУОШТ эзэмших эрхтэй 17 газартай боловч Булган аймгийн төвд байрлах УЦУОШТ, Тэшиг, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд байрлах 4 газрыг санхүүгийн тайланд газар эзэмших гэрчилгээнээс зөрүүтэй тайлагнасан. /Булган аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- ТШЗ-ийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 19 газраас 7 газрын гэрчилгээ байхгүй, 16 газар нь кадастрын зураггүй, газрын гэрчилгээ болон хэмжээ зөрүүтэй байна. /Дундговь аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй, бүртгэлд тусгаагүй, цахим бүртгэлийн системд бүртгэгдээгүй байна. /Хөвсгөл аймгийн УЦУОШТ-д зөвлөмж/
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ээлжийн амралтын хугацааны талаар тодорхой тусгаагүй. /Говьсүмбэр УЦУОШТ-зөвлөмж/
- Цалингийн хэмнэлтээс албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо тайлант онд ажилласан хугацааны үр дүнгээр урамшууллыг тооцож олгоогүй, 417.0 сая төгрөгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар зарцуулаагүй, ЗГ-ын 2023 оны 52 дугаар тэмдэглэлд туссан чиглэлийг баримтлаагүй байна. /Говьсүмбэр УЦУОШТ-зөвлөмж/
- ТШЗ-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэл нь бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашиглаагүй байна. /УЦУОСМХ болон Говьсүмбэр аймгийн УЦУОШТ-т зөвлөмж/

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ЦУОШГ-ын ТШЗ-ийн завсрын аудитаар 203.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 145.5 сая төгрөгийн алдааг залруулж, 2.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 55.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4 албан шаардлага, 4 зөвлөмж өгснийг 100.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
 Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	508,454.4	4	508,454.4	100.0
Зөвлөмж	4	95,674.0	4	95,674.0	100.0
Нийт дүн	8	604,128.4	8	604,128.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ЦУОШГ-ын төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хэрэгжиж байгаа гадны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, тайлагналын асуудлуудыг шалгаж, нягтлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 15,765.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 15,762.5 сая төгрөгийн 18 алдааг залруулж, 2.6 сая төгрөгийн 1 алдааг 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 423.8 сая төгрөгийн 38 зөрчлөөс 15.4 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 264.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлж, 144.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 16 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 26 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 17 байгууллага "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, 9 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Нийт илрүүлсэн 423.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээний хэмнэлтээс оны эцэст 107.1 сая төгрөгийн компьютер, техник хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, бусад этгээдээс шууд худалдан авсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 425.3 сая төгрөгийн өр төлбөр болон авлага үүсгэсэн, цалин урамшуулал зөрүүтэй олгосон, шууд худалдан авалт хийсэн, анхан шатны баримт бүрдэл хангаж ажиллаагүй зэрэг дотоод хяналттай холбоотой зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.2 Зөвлөмж

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Булган, Дундговь, Хөвсгөл аймгуудын УЦУОШТ, УЦУОСМХ зэрэг байгууллагууд газрын гэрчилгээгүй, кадастрын зураггүй, газрын хэмжээ зөрүүтэй, санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй, цахим бүртгэлийн системд бүртгэлгүй зэрэг газартай холбоотой зөрчлүүд байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТТЗ-ийн харьяа байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрын асуудлаар дотоод хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймгийн УЦУОШТ	1	15,122,915.0	1	15,122,915.0			1	15,122,915.0				
2	Баянхонгор УЦУОШТ	1	6,500.0			1	6,500.0	1	6,500.0				
3	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	1	4,630.0			1	4,630.0	1	4,630.0				
4	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	240.6			1	240.6	1	240.6				
5	Дорнод УЦУОШТ	1	1,120.6	1	1,120.6			1	1,120.6				
6	Орхон аймгийн УЦУОШТ	3	23,330.0	3	23,330.0			3	23,330.0				
7	Өмнөговь аймгийн УЦУОШТ	2	1,083.2			2	1,083.2	2	1,083.2				
8	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	3	344,503.4	1	1,300.0	2	343,203.4	3	344,503.4				
9	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	2	9,937.9	1	9,300.0	1	637.9	2	9,937.9				
10	Төв аймгийн УЦУОШТ	1	10,984.7			1	10,984.7	1	10,984.7				
11	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	1	578.3			1	578.3	1	578.3				
12	Хэнтий аймгийн УЦУОШТ	1	236,683.0	1	236,683.0			1	236,683.0				
13	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	1	2,605.0			1	2,605.0			1	2,605.0	1	2,605.0
Дүн		19	15,765,111.7	8	15,394,648.6	11	370,463.1	18	15,762,506.7	1	2,605.0	1	2,605.0



Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын нэр										
Архангай аймгийн УЦУОШТ	1	7,561.4	1	7,561.4	1	18,899.5	2	42,999.0		
Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	3	61,898.5		-			2	222.3		
Булган аймгийн УЦУОШТ	3	2,655.4	1	2,433.1	3	2,154.4	1	11,438.6		
Говь-Алтай аймгийн УЦУОШТ	4	13,593.0					1	6,878.0		
Дархан-Уул аймгийн УЦУОШТ	2	7,111.6	1	233.6			3	576.0		
Дорноговь аймгийн УЦУОШТ	3	576.0			1	1,100.0				
Дорнод аймгийн УЦУОШТ	1	1,100.0			2	15,112.5	2	49,287.9		
Дундговь аймгийн УЦУОШТ	2	15,112.5								
Дунговь аймгийн УЦУОШТ	4	50,070.5	2	782.6	2	74,956.0	1	-		
Орхон аймгийн УЦУОШТ	2	74,956.0			2	18,119.0	3	695.9		
Сүхбаатар аймгийн УЦУОШТ	5	19,423.6	2	1,304.6						
Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	3	695.9								
Хөвсгөл аймгийн УЦУОШТ	1	3,122.7	1	3,122.7	1	107,124.0				
Хэнтий аймгийн УЦУОШТ	1	107,124.0			1					
Цаг уур, орчны шинжилгээний газар	1	-			1	26,829.1	1	32,000.0		
Цаг уур, орчны шинжилгээний газар ТТЗ										
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	2	58,829.1			14	264,294.5	16	144,097.7		
Дүн	38	423,830.2	8	15,438.0	14	264,294.5	16	144,097.7		

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	1	314,896.4					1	314,896.4				
Баянхонгор УЦУОШТ	1	207,384.9			1	207,384.9						
Дархан-Уул аймгийн УЦУОШТ	1	150.0					1	150.0				
Дорноговь УЦУОШТ	1	1,015,098.4			1	1,015,098.4						
Орхон аймгийн УЦУОШТ	1	80,754.6					1	80,754.6				
Өмнөговь УЦУОШТ	1	445.7					1	445.7				
Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	0					1	-				
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	1	0			1	0						
Дүн	8	1,618,730.0			3	1,222,483.3	5	396,246.7				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Булган УЦУОШТ	1						1					
Дундговь аймгийн УЦУОШТ	1						1					
Хөвсгөл УЦУОШТ	1						1					
Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	3	416,988.0					3	416,988.0				
Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	2	0					2	0				
Цаг уур, орчны шинжилгээний газар ТТЗ	1	0					1	0				
Дүн	9	416,988.0			0	0	9	416,988.0				
Нийт дүн	17	2,035,718.0			3	1,222,483.3	14	813,234.7				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 617/А0160722

Улаанбаатар хот

СНАГ-2024/78/МА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээний хэмнэлтээс оны эцэст 107,124,000.00 /нэг зуун долоон сая нэг зуун хорин дөрвөн мянга / төгрөгийн компьютер, техник хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-д "Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 195 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Оюунжаргал/, Ахлах нягтлан бодогч /Д.Отгонбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264,30

Z: Албан шаардлагын 2024.03.15 СНАГ-43.Docx

0001080602



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 618/АД/60122

Улаанбаатар хот

СИНАГ-2024/23/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр авлага үүсгэсэн, цалин, урамшуулал илүү олгосон, шууд худалдан авалт хийсэн, анхан шатны баримт бүрдэл хангаж ажиллаагүй зэрэг нийт 450.6 сая төгрөгийн дотоод хяналттай холбоотой зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Харьяа байгууллагуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Оюунжаргал/, Ахлах нягтлан бодогч /Д.Отгонбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.БОЛД
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Утас: 98800000 баарын IV байр